

Эрүүл мэндийн сайдын тушаал
2009 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 323

Томуугийн тандалтыг
эрчимжүүлэх тухай

ДЭМБ-ын Ази-Номхон далайн бүсийн орнуудын Томуугийн үндэсний төвүүдийн гуравдугаар зөвлөлдөх уулзалтаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Томуугийн харуулдан тандалтын I, II, III зэрэглэлийн нэгжийн жагсаалтыг нэгдүгээр, үйл ажиллагааны чиглэл, тандалтын зааврыг хоёрдугаар, сорьц авах, хадгалах, тээвэрлэх журмыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн дэд сайд /Ж.Цолмон/-д даалгах нь:

а/. Биоаюулгүй ажиллагааны III зэрэглэлийн лаборатори бүхий нэгдсэн лабораторийг 2010 онд багтаан Халдварт өвчин судлалын үндэсний төвд байгуулах.

б/. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв, Дархан-Уул, Орхон аймгийн вирус судлалын лабораторийн томуугийн оношлогоонд шаардагдах тоног төхөөрөмжийг Дэлхийн Банкны “Шувууны томуу, хүний томуугийн цартахалтай тэмцэх чадавхийг сайжруулах” төслийн шугамаар хангах.

3. Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д. Нямхүү)-д даалгах нь:

а/. Томуугийн тандалтын албыг энэ оны 10 дугаар сард багтаан байгуулж, томуугийн тандалт, цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах талаарх ДЭМБ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах.

б/. ДЭМБ-ын зөвлөмж болгосон томуугийн вакцинаар эрүүл мэндийн байгууллагын эмч, ажиллагсдыг дархлаажуулах арга хэмжээг жил бүр зохион байгуулах.

в/. Дархан-Уул, Орхон аймгийн вирус судлалын лабораторийн эмч, мэргэжилтнийг томуугийн оношлогооны чиглэлээр сурган мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах.

г/. Томуугийн цартахлын вирусийн эргэлтийн хүрээг тогтоон холбогдох насны бүлгээс цусны сорьц цуглуулах, банк бүрдүүлэх.

д/. АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төвтэй хамтран хэрэгжүүлж буй төслийн шугамаар байгуулсан www.flu.mn вэбсайтын үйл ажиллагааг тогтмолжуулах.

е/. Томуугийн Үндэсний тавдугаар зөвлөлгөөнийг энэ оны 10 дугаар сарын 7-8-нд зохион байгуулах, цаашид зөвлөлгөөнийг жил бүрийн 10 дугаар сарын нэгдүгээр долоо хоногт багтаан зохион байгуулж байх.

4. Шувуу, адуу, гахай болон бусад амьтны томуугийн вирүсийн байгаль дахь эргэлтийг тандан судлахыг Байгалийн голомтот халдварт өвчнийг судлах үндэсний төв /Д.Отгонбаатар/-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2006 оны 253 тоот тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД

С.ЛАМБАА

**Томуугийн харуулдан тандалтын I, II, III
зэрэглэлийн нэгжийн жагсаалт**

I зэрэглэлийн харуулдан тандалтын нэгж

Нэг. Нийслэл хотод:

1.1 Өрхийн эмнэлэг

д/д	Дүүргийн нэр	Өрхийн эмнэлгийн нэр
1	Баянзүрх	“Амгалан итгэхүй”, “Эрүүл өрх”, “Насан урт”
2	Хан-Уул	“Энх титэм”, “Манал үйлс”, “Амин тус”
3	Сүхбаатар	“Санколл”, “Энх Элбэрэл”, “Үйлс нэгтэн”
4	Сонгино хайрхан	“Буянт манал”, “Энх-Элбэрэл”, “Өнө-ачит”
5	Баянгол	“Итгэл угтах”, “Гурван санчир”, “Шар дэгд”
6	Чингэлтэй	“Тэгш мэнд”, “Шижид дүг”, “Тэгш –Өлзий”
7	Багануур	“Энэрэлт –Өлзий”, “Биваангирд”, “Энх өрх”,
8	Налайх	“Амь-Эрдэнэ”

1.2.Эмнэлэгт суурилсан харуулдан тандалтын нэгж

д/д	Дүүргийн нэр	Эмнэлгийн нэр
1.	Баянзүрх	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
2.	Хан-Уул	
3.	Сүхбаатар	
4.	Сонгино хайрхан	
5.	Баянгол	
6.	Чингэлтэй	
7.	Багануур	
8.	Баянзүрх	ХӨСҮТ
9.	Баянгол	ЭНЭШТ

Хоёр. Аймагт:

2.1 Өрхийн эмнэлэг

д/д	Аймгийн нэр	Өрхийн эмнэлгийн нэр
1.	Дорноговь	“Агатова”, “Гоёомэнд”, “Мишээлт мана”, “Төмөр зам”,
2.	Дорнод	“Асралт үйлс”, “Дорны ирээдүй”, “Мянган жаргалан”, “Цээнэцэцэг”, “Эрүүл зон”, “Ягаан цээнэ”
3.	Өвөрхангай	“Наран дөш”, “Түшиг дөлгөөн”, “Уян сэтгэл”, “Энхийн хүрд”
4.	Сэлэнгэ	“Зөвлөх”, “Номтхан”, “Хадан хүй”, “Эгнэшгүй”, “Эмнэх”
5.	Ховд	“Баатархайрхан”, “Бугат”, “Буянт”, “Жаргалант”, “Рашаант”
6.	Орхон	“Мөнхсүндрэл”, “Цагаан агь”, “Учралтбаяр”, “Мөнхийн гэгээ”, “Элбэрэлт үйлс”, “Үйлсбадрах”, “Нийцэл”, “Ачлалт нар”, “Анхны оч”, “Мэндбулаг”, “Хос чагнуур”, “Итгэлийн эрэл”, “Гэрэлт мандах”
7.	Дархан-Уул	“Гос хот”, “Энэрэлт наран”, “Гэрэлтэй”, “Аминхолбоо”, “Түвшинхолбоо”

2.2 Эмнэлэгт суурилсан харуулдан тандалтын нэгж

д/д	Аймгийн нэр	Эмнэлгийн нэр
1	Дорноговь	Нэгдсэн эмнэлэг
2	Дорнод	Бүсийн оношлогоо,эмчилгээний төв
3	Өвөрхангай	Бүсийн оношлогоо,эмчилгээний төв
4	Сэлэнгэ	Нэгдсэн эмнэлэг
5	Ховд	Бүсийн оношлогоо,эмчилгээний төв
6	Орхон	Нэгдсэн эмнэлэг
7	Дархан-Уул	Нэгдсэн эмнэлэг

II зэрэглэлийн харуулдан тандалтын нэгж

Нэг. Нийслэл хотод:

Д/д	Эмнэлгийн нэр	Дүүрэг
1	Улсын Клиникийн 1-р эмнэлэг	Сүхбаатар дүүрэг 1-р хороо
2	Шастины нэрэмжит нэгдсэн 3-р эмнэлэг	Баянгол дүүрэг Ард Аюушийн гудамж
3	Хавдар судлалын үндэсний төв	Баянзүрх дүүрэг

Хоёр. Аймагт:

д/д	Аймаг, сумын нэр	Өрхийн эмнэлгийн нэр
1.	Булган аймаг, Булган сум	“Жаргахуй”, “Эмийн цэцэглэн”, “Цоожид” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
2.	Хөвсгөл аймаг, Мөрөн сум	“Эрчим”, “Дэлгэр мөрөн”, “Буян”, “Энэрэл”, “Тулга”, “Далай-Элбэрэл” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
3.	Төв аймаг, Зуун мод сум	“Баруун зуун мод”, “Дэлгэр”, “Биндэръяа”, “Зуун мод”, “Номт энэрэлт ач” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
4.	Хэнтий аймаг, Өндөрхаан сум	“Ач манал”, “Хэрлэн дом”, “Оюуны шим” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
5.	Говьсүмбэр	Төмөр замын өрхийн эмнэлэг, “Энх тус дэм” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
6.	Дундговь аймаг Мандалговь сум	“Суварга эрдэнэ”, “Боржигон мандал”, “Өлзийт мандал” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
7.	Өмнөговь аймаг, Даланзадгад сум	“Шинэ билэг”, “Энхийн хүслэн”, “Өнө Орших” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
8.	Сэлэнгэ аймаг, Мандал сум	“Баян”, “Бату”, “Тоохуу-Гос”
9.	Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сум	Сумын хүн эмнэлэг
10.	Өвөрхангай аймаг, Хархорин сум	“Энэрэлт-Хархорин”, “Энэрэлт-Ач”
11.	Дорноговь аймаг, Замын-Үүд	Сумын нэгдсэн эмнэлэг

III Зэрэглэлийн харуулдан тандалтын нэгж

1. Аймагт:

д/д	Аймгийн нэр	Өрхийн эмнэлгийн нэр
1.	Увс аймаг, Улаангом сум	“Элбэг-өгөөж”, “Дунцагаан”, “Мөнхбишрэлт”, “Батүржихүй” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
2.	Завхан аймаг, Улиастай сум	“Энх хөгжил”, “Наран”, “Биндэргарав”, “Мезкал”, “Дөрвөн оноо”, “Намчинмамба”, “Надсэлмамба” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
3.	Архангай аймаг, Цэцэрлэг сум	“Ар энхжин”, “Ар мөнгөн чагнуур”, “Ар мөнхжин”, “Ар рашаант”, “Ар манал” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
4.	Сүхбаатар аймаг, Баруун-урт сум	“Энэрэл”, “Энхжин”, “Тэмүүлэн” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
5.	Баян-өлгий аймаг, Өлгий сум	“Раван”, “Чинагэр”, “Нэйрм”, “Жансаяан” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
6.	Баянхонгор аймаг, Баянхонгор сум	“ЭБСУ”, “Наран мандмал”, “Суприсор”, “Оточ мандал”, “Энхбүрд”, “Оточ номгон” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг
7.	Говь-Алтай аймаг, Алтай сум	“Жаргалан алтай”, “Марал алтай”, “Энх алтай”, “Энэрэл алтай” өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг

**Томуугийн харуулдан тандалтын I, II, III
зэрэглэлийн нэгжийн үйл ажиллагааны чиглэл,
тандалтын заавар**

1. Томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүдэд АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төвийн “Томуугийн сүлжээг байгуулан бэхжүүлэх” төслийн хүрээнд 2004 оноос ажиллаж байгаа Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын 8 дүүргийн өрхийн эмнэлгүүд, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, ЭНЭШТ, ХӨСҮТ багтана.

1.1. Харуулдан тандалтын **нэгжийн** эмч бүр томуу, томуу төст өвчин (ТТӨ), амьсгалын замын хүнд халдвар (АЗХХ)-ын тохиолдол болон голомтолсон өвчлөлийг дараах тодорхойлолтын дагуу тусгайлан бүртгэж, шалгуур үзүүлэлтэд тохирсон өвчтнүүдээс хамар,залгиурын сорьц авна.

1.1.1 38 °C хэмээс дээш гэнэт халуурах, ханиалгах, хоолой өвдөх зэрэг эмнэл зүйн шинж тэмдэг илэрч, бусад онош үгүйсгэгдсэн тохиолдлыг “томуу, томуу төст өвчин”,

1.1.2 Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг бүхий (38 °C хэмээс дээш гэнэт халуурах, ханиалгах, хоолой өвдөх зэрэг эмнэл зүйн шинж тэмдэг илэрч, бусад онош үгүйсгэгдсэн тохиолдол) өвчтөнд амьсгалын тоо олшрох, амьсгалахад бэрхшээлтэй болох эсвэл эмнэлэгт хэвтэх шаардлагатай тохиолдлыг “амьсгалын замын хүнд халдвар”,

1.1.3 Нэг хамтлагийн 2 ба түүнээс дээш хүнд 7 хоногийн хугацаанд эмнэлзүйн адил шинж тэмдэг гэнэт илрэхийг “голомтолсон өвчлөл” гэж үзэн тус тус бүртгэнэ.

1.2. ТТӨ, АЗХХ ба голомтолсон өвчлөлийн шалгуур үзүүлэлтэд тохирох өвчтнүүдээс сорьц цуглуулж, 7 хоног тутам ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид хуваарийн дагуу хүргүүлнэ.

2. Томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжүүдэд Булган, Хөвсгөл, Төв, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймгийн төвийн өрхийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгүүд, хилийн боомт буюу орчил ихтэй, 10000-аас дээш хүн амтай зарим сум, суурин газрууд (Сэлэнгэ аймгийн Мандал, Алтанбулаг, Дорноговь

аймгийн Замын-Үүд, Өвөрхангай аймгийн Хархорин), Улаанбаатар хотын Улсын Клиникийн I эмнэлэг, Шастины нэрэмжит нэгдсэн III эмнэлэг, Хавдар Судлалын Үндэсний Төв багтана.

2.1. Харуулдан тандалтын цэгийн эмч бүр ТТӨ, АЗХХ-ын тохиолдол ба голомтолсон өвчлөлийг 1.1.1, 1.1.2, 1.1.3 дахь тодорхойлолтын дагуу тусгайлан бүртгэж, шалгуур үзүүлэлтэд тохирох өвчтнүүдээс хамар залгиурын сорьц цуглуулж, ТҮТ-д хүргүүлнэ.

3. Томуугийн харуулдан тандалтын III зэрэглэлийн нэгжүүдэд Увс, Завхан, Архангай, Сүхбаатар, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай аймгийн төвийн өрхийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгүүд багтана.

3.1.ТТӨ-ийг 1.1.1 дэх тодорхойлолтын дагуу тусгайлан бүртгэж, 7 хоног тутам тандалтын мэдээг ТҮТ-д мэдээлнэ.

4. Аймагт өрхийн болон нэгдсэн эмнэлгийн дүн бүртгэгч өдөр тутам, 7 хоногийн тандалтын мэдээг өрх, нэгдсэн эмнэлгийн тасаг бүрээс авч нэгтгэн, өрхийн ахлагч, тасгийн эрхлэгчээр хянуулж, аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн томуугийн тандалт хариуцсан халдвар судлагч эмч эсвэл дүн бүртгэгчид мэдээлнэ. Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн томуугийн тандалт хариуцсан халдвар судлагч эмч эсвэл дүн бүртгэгч нь “Маягт 1”-ын дагуу өдөр тутам, “Маягт 2”-ын дагуу 7 хоногт 1 удаа ХӨСҮТ-ийн томуугийн тандалтын албаны /ТТА/ 45-48-00, 45-58-47 утсанд, боломжтой бол цахим хэлбэрээр тогтмол мэдээлнэ.

5. Нийслэлд өрхийн болон дүүргийн нэгдсэн эмнэлгийн дүн бүртгэгч эмч өдөр тутам, 7 хоногийн тандалтын мэдээг өрхийн болон дүүргийн нэгдсэн эмнэлгийн тасаг бүрээс авч нэгтгэн, өрхийн ахлагч, тасгийн эрхлэгчээр хянуулж, дүүргийн ЭМН-ийн томуугийн тандалт хариуцсан халдвар судлагч эмч эсвэл дүн бүртгэгчид мэдээлнэ. Дүүргийн ЭМН-ийн томуугийн тандалт хариуцсан халдвар судлагч эмч эсвэл дүн бүртгэгч нь ТҮТ-д “Маягт 1”-ын дагуу өдөр тутам, “Маягт 2”-ын дагуу 7 хоногт 1 удаа ХӨСҮТ-ийн ТТА-ны 45-48-00, 45-58-47 утсанд, боломжтой бол цахим хэлбэрээр тогтмол мэдээлнэ.

6.Улсын клиникийн нэгдсэн эмнэлгүүд, үндэсний төвийн дүн бүртгэгч нар клиникийн нэгдсэн эмнэлэг, үндэсний төвийн тасаг, нэгжээс тандалтын мэдээг авч нэгтгэн, тасаг нэгжийн даргаар хянуулж, ХӨСҮТ-ийн ТТА-д “Маягт 1”-ын дагуу өдөр тутам, “Маягт 2”-ын дагуу 7 хоногт 1 удаа ХӨСҮТ-ийн ТТА-д ҮТ-ийн 45-48-00, 45-58-47 утсанд, боломжтой бол цахим хэлбэрээр тогтмол мэдээлнэ.

Маягт 1.

ТТӨ, АЗХХ-ын бүртгэл

Үзүүлэлт	Насны бүлэг								Нийт
	0-11	1-4	5-9	10-15	16-24	25-44	45-64	65+	
Амбулаторийн нийт үзлэг									
ТТӨ-ий нийт тохиолдол									
Үүнээс: Амьсгалын замын хүнд халдвар (АЗХХ)									
Үүнээс: Голомтол сон өвчлөл									
Амбулаторийн нийт үзлэгт ТТӨ - ий эзлэх хувь									
Түргэн тусламжийн дуудлагын тоо									

Тайлбар: Голомтолсон өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд “нийт” гэсэн баганад өвчлөлд өртсөн хамтлагийн тоог тавина. Жишээ нь 3 айлыг 7 хүн амьсгалын замын халдвараар 7 хоногийн хугацаанд өвчилсөн бол “нийт” баганад 3 гэсэн тоог тавьж, 7 тохиолдлыг насны бүлгээр бүртгэнэ.

Томуугийн харуулдан тандалтын нэгжийн сорьц
авах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх журам

Нэг.Томуу, томуу томуу төст өвчин, амьсгалын замын хүнд халдвар, голомтолсон өвчлөл гэсэн тохиолдлыг тодорхойлолтын дагуу оношлосон эмч, эмчилгээ эхлэхээс өмнө өвчний эхний 3 хоногт сорьцыг цуглуулна.

ТТӨ, АЗХХ, голомтолсон өвчлөлийн үед хамрын арчдас, хамрын угаадас, ийлдэс, тууралтат халдварын үед хоолойн арчдас, нас барсан тохиолдолд эд, эсийн сорьц авна. Шинжлэгдэхүүн авах эмч, эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцсыг бүрэн өмсөнө. Хэрэв өвчтний өгүүлэмж болон эмнэлзүйн шинж нь амьсгалын замын үүсгэгч тодорхойгүй, хүнд халдвар гэж сэжиглэхээр байвал НЕРА шүүлтүүр бүхий зориулалтын амны хаалт зүүнэ.

1.1 .Шинжлэгдэхүүн цуглуулахад шаардагдах зүйлс:

- Халад
- Маск
- Бээлий
- 7-8 см урт уян иштэй ариун бамбар
- 2-4 мл вирүс зөөвөрлөх орчин бүхий бөглөөтэй хуруу шилнүүд
- Хуруу шил тогтоогуур
- Шинжлэгдэхүүн зөөвөрлөх зориулалтын сав
- Шинжлэгдэхүүнийг дагалдах бичиг

1.2. Шинжлэгдэхүүн авах

1.2.1.Хамрын арчдас авах: Өвчтний нусыг нийлгэх буюу ариутгасан бамбараар хамрын хөндийг арчиж цэвэрлээд насанд хүрэгчдийг хэвтүүлж, хүүхдийг хүнд тэврүүлж суулгана. Зүүн гарын эрхий, долоовор хуруугаар өвчтнийхээ хамрын үзүүрээс чимхэж, баруун гартаа ариун бамбар барьж болгоомжтой зөөлөн эргүүлэх хөдөлгөөнөөр хамрын дунд самалдаг хөндийн гүнд том хүнд 4-5 см, хүүхдэд 2-3 см оруулангаа бамбараа салст бүрхүүл рүү шахаж эргүүлэн арчдас авч, 2-3 мл буфержсэн ариун физиологийн уусмал буюу Хенксийн

уусмалтай хуруу шилэнд хийнэ. Мөн энэ байдлаар хамрын нөгөө хөндийгөөс арчдас авч дээрх уусмалд хийнэ.

1.2.2. Хамрын угаадас авах: Өвчтнийг дээрх байдлаар бэлтгэж, суулгаад хамрын хөндий тус бүрт зүүг уян гуурсаар орлуулсан тариураар 4-6 мл ариун физиологийн уусмал хийнгүүт буцаан соруулж ариун хуруу шилд хийнэ. Ийм тариургүй үед дээрх уусмалыг хамарт дусаангуут өвчтнийг бөхийлгөн залгиулахгүйгээр ариун петрийн аяга юмуу юүлүүрээр дамжуулан хуруу шилэнд тосч авна.

1.2.3. Тууралтын шингэн авах: Цэврүүт тууралтын үед гарсан тууралтаас цэврүүний шингэнийг 1 мл-ийн хэмжээтэй тариураар соруулан авч тэжээлт орчин бүхий саванд хийнэ.

1.2.4. Тавны арчдас авах: Шархны тавны хэсгээс бамбараар арчдас авч зөөвөрлөх орчинтой хуруу шилэнд хийнэ.

1.2.5. Эд, эсийн сорьц авах: Уушгины эдийн гүнээс буюу гуурсан хоолойноос 0.5 см талтай шоо хэлбэртэй огтолж аваад ариун саванд хийж таглана.

1.2.6. Ийлдэс цуглуулах: Өвчтний ийлдэст өвөрмөц эсрэг биеийн таньц тодорхойлох зорилгоор өвчтнөөс 14-21 хоногийн зайтай хос ийлдсийг ердийн аргаар авна.

1.3. Шинжлэгдэхүүнийг хадгалах, зөөвөрлөх

1.3.1. Хамрын арчдас, хамрын угаадас, хоолойн арчдас, тууралтын шингэн, тавны арчдсыг нийслэлд 24 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, хөлдөөхгүйгээр тээвэрлэж лабораторид хүргэнэ.

Хөдөө орон нутагт өдөрт нь тээвэрлэх боломжгүй үед -70°C -д хадгалж, эсвэл мөсөн элементтэй саванд 48 цагийн хугацаанд хөлдөөхгүйгээр тээвэрлэж лабораторид ирүүлнэ. Эд, эсийн сорьцийг хөлдөөхгүйгээр аль болох хурдан лабораторид хүргэнэ. Боломжгүй бол -70°C -д хадгалж, хөлдүүгөөр тээвэрлэнэ.

1.3.2. Ийлдсийг 7 хоногийн дотор лабораторид илгээх боломжтой бол хөлдөөлгүй сэрүүн нөхцөлд хадгалж, тээвэрлэнэ. Боломжгүй бол -20°C д хадгалж байгаад хөлдүүгээр тээвэрлэж лабораторид хүргэнэ.

Анхааруулга:

Шинжлэгдэхүүн илгээх бүрт хэн, хэзээ, ямар тээврийн хэрэгслээр, ямар шинжлэгдэхүүнийг илгээж байгааг харуулдан тандалтын нэгжийн ахлагч нар

ХӨСҮТ-ийн Амьсгалын замын вирус судлалын лабораторид 451183, 455847 дугаарын утсаар мэдэгдэнэ.

1.4.Шинжлэгдэхүүнийг хаяглах

1.4.1.Шинжлэгдэхүүний савыг дараах асуумжийн дагуу хаяглаж, шошгыг саванд наана.

Үүнд:

Сорьц №..../....

Эмнэлгийн байгууллагын нэр _____

Өвчтний овог нэр _____

Нас----- хүйс (зур) эрэгтэй, эмэгтэй

Хаяг _____

Эмнэлзүйн онош _____

Голомтолсон өвчлөлийн тохиолдол

Өвчин эхэлсэн: _____ он _____ сар _____ өдөр _____

Сорьц авсан эмч, сувилагчийн нэр: _____

Сорьцийн төрөл _____

Сорьц авсан: _____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ минут

Сорьцийг тээвэрлэлтэд өгсөн:

_____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ минут

Шинжилгээний хариу _____

2. Сорьцонд шинжилгээ хийх, эргэж мэдээлэх

Сорьцонд дараах шинжилгээнүүдийг хийнэ.

Үүнд:

2.1.Сорьц болгонд томуугийн вирус илрүүлэх шинжилгээг ердийн буюу бодит хугацааны полимеразийн гинжин урвал (ПГУ);

2.2.Дээрх урвалаар эерэг гарсан сорьцийг эсийн өсгөвөр, тахианы үр хөврөлд халдааж томуугийн вирус ялгах шинжилгээ;

2.3.Вирүсийн өсгөврөөс цус наалдуулах, цус наалдуулахыг саатуулах урвалаар эсрэг төрөгчийн хэвшинжийг тодорхойлох;

2.4.ПГУ-аар вирүсийн дэд хэвшинж тодорхойлох;

2.5.Вирүсийн эмийн бодист тэсвэржилтийг ДЭМБ-ын зөвлөмж болгосон аргаар тодорхойлох;

2.6.Ийлдсэнд эсрэг биеийн таньц тодорхойлох шинжилгээг цус наалдахыг саатуулах, эсийн өсгөвөрт саармагжуулах, нейраминидазын идэвх саатуулах аргаар тус тус хийнэ;

3.Шинжилгээний дүнг 7 хоног тутамд утсаар болон цахим хэлбэрээр эргэж мэдээлнэ.

4. Ялгасан вирүсийн зарим омгийг АНУ-ын Өвчний Хяналт, Сэргийлэлтийн Төв, Япон улсын Халдварт Өвчний Үндэсний Хүрээлэнгийн Томуугийн Лавлагаа төвд илгээнэ.

5.ДЭМБ-ын Ази Номхон Далай, Зүүн Өмнөд Азийн Бүсийн ТҮТ-үүдийн гуравдугаар зөвлөлдөх уулзалтын зөвлөмжийн дагуу томуугийн А(Н1N1) шинэ хувилбарын вирүсийг тодорхойлох шинжилгээг ХӨСҮТ-ийн Амьсгалын замын вирүс судлалын лабораторид биоаюулгүй ажиллагааны 2+ орчинд хийнэ.

3. ТТӨ-ий харуулдан тандалтын нэгжийн

ХӨСҮТ-д сорьц хүргүүлэх

3.1.Томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүдийн эмч нар 7 хоногт 1 удаа ХӨСҮТ-ийн ТТА-ны баталсан хуваарийн дагуу, II зэрэглэлийн цэгүүдийн эмч нар голомтолсон өвчлөл бүртгэгдсэн үед сорьц цуглуулж, дагалдах баримтын хамт “Шинжлэгдэхүүн авах, хадгалах, тээвэрлэх журам”-ын дагуу ХӨСҮТ-ийн Вирүс судлалын лабораторид хүргэнэ.

3.2. Харуулдан тандалтын нэгжийн эмч нар ТТӨ-ий дархлал тогтцын шинжилгээнд зориулан зохих журмын дагуу цус авч ийлдсийг ялган ХӨСҮТ-ийн Амьсгалын замын вирүс судлалын лабораторид ирүүлнэ.

3.3. Харуулдан тандалтын нэгжийн ахлагч нь тандалтын явцын байдлыг 14 хоног тутамд ТТӨ-ий тандалтын багт утас, цахим шуудан, факсаар мэдээлнэ.

Маягт 2.

Эмнэлэгт суурилсан тандалтын мэдээний бүртгэл

Гараг	Больницын орны хөдөлгөөн																																					
	Огноо	Батлагдсан нийт орны тоо	Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт өвчтөн								Эдгэрч гарсан, шилжсэн						Нас барсан						Шинээр хэвтсэн						Энэ 7 хоногийн эцэст байгаа									
			Бүгд	Үүнээс						Бүгд	Үүнээс					Бүгд	Үүнээс					Бүгд	Үүнээс					Бүгд	Үүнээс									
				0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас	60-с дээш		0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас		60-с дээш	0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас		50-59 нас	60-с дээш	0-4 нас	5-9 нас	10-19 нас		20-49 нас	50-59 нас	60-с дээш							
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38		
Да																																						
Мя																																						
Лх																																						
Пү																																						
Ба																																						
Бя																																						
Ня																																						
Σ																																						
Да																																						
Мя																																						
Лх																																						
Пү																																						
Ба																																						
Бя																																						
Ня																																						
Σ																																						

Үүнээс уушигний үрэвсэл (АЗХХ)-ээр хүндэрсэн

Гараг	Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт өвчтөн							Эдгэрч гарсан, шилжсэн						Нас барсан						Шинээр хэвтсэн						Энэ 7 хоногийн эцэст байгаа нийт өвчтөн						Үүнээс голомтолсон	Судалгаа гаргасан				
	Бүгд	Үүнээс						Бүгд	Үүнээс						Бүгд	Үүнээс						Бүгд	Үүнээс														
		0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас	60-с дээш		0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас	60-с дээш		0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас	60-с дээш		0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас	60-с дээш									
39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59	60	61	62	63	64	65	66	67	68	69	70	71	72	73	74	75	
Да																																					
Мя																																					
Лх																																					
Пү																																					
Ба																																					
Бя																																					
Ня																																					
Σ																																					
Да																																					
Мя																																					
Лх																																					
Пү																																					
Ба																																					
Бя																																					
Ня																																					
Σ																																					

